

МОНГОЛ ХЭЛНИЙ НЭРИЙН ХАМААТУУЛАХ ЁС

А. Лхагвасүрэн *

1. Удиртгал

Монгол хэлний хамаатуулах ай нь монгол хэлний өгүүлбэрийн бүтцэд маш чухал үүрэгтэй юм. Өнөөгийн хэлзүйн судалгаануудад монгол хэлний нэрийн хамаатуулах ёсыг ихэвчлэн хамаатуулах утга болон, ялгах утгыг илэрхийлнэ гэсэн гол үндсэн үүрэгтэй хэмээн тодорхойлсон байдаг. Гэтэл ялангуяа монгол хэлний биеийн хамаатуулах ай нь зөвхөн биед хамаатуулдаг гэж авч үзэхэд өрөөсгөл юм. Жишээлбэл

1. Аав минь ирсэн үү?
2. Аав чинь ирсэн үү?
3. Аав нь ирсэн үү?

Дээрх 3 өгүүлбэрт аав гэсэн нэр нь 1, 2, 3 биеийн нөхцөлийг авсан байна. Тиймээс миний аав, чиний аав, түүний аав гэсэн утгатай. Гэтэл нөхцөл байдлаас хамаарч аав чинь, аав нь гэсэн хоёр аав адил аав байж болно.

4. Сайн нь иржээ.

Энэ өгүүлбэрт 3-р биеийн төлөөний үг нь хамаатуулах утга илэрхийлж чадахгүй учир ялгах утга илэрхийлж байна гэж авч үзэх шаардлагатай. Гэтэл хэрвээ сайн гэсэн тэмдэг нэрийн ард буй 3-р биеийн хамаатуулах нөхцөлийг авчихвал өгүүлбэрийн утга бүрэн өөрчлөгдөнө. Тэмдэг нэрийг өгүүлэгдэхүүн буюу үйлийн эзэн болгож байна гэсэн үг. Тиймээс зөвхөн ялгах утга илэрхийлж байна гэж үзэхэд өрөөсгөл байна.

Хамаатуулах нөхцөлийн өгүүлбэрт гүйцэтгэж буй үүргийг илүү олон талаас нарийвчлан авч үзэх нь зүйтэй. Энэхүү судалгаандаа монгол хэлний нэрийн хамаатуулах ёс, түүний гүйцэтгэж буй үүргийг жишээн дээр тулгуурлан ямар утга илэрхийлж буйг тодорхойлж буйг авч үзэхийг зорив. Мөн онцолбор гишүүн гэсэн ойлголтод түшиглэн хамаатах ёсны дээр дурьдсан асуудлуудыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхийг оролдлоо.

2. Монгол хэлний нэрийн хамаатуулах айн тухай

Монгол хэлэнд эзэмшигч эзэн эзэмшигдэгч юм хоёрын хоорондын хамаатах харилцааг заахын зэрэгцээгээр нэрлэсэн зүйлээ төрлийнх нь олон юм үзэгдлээс онцлон ялгаж үзүүлэх хэлзүйн айг хамаатуулах ёс гэнэ. Монгол хэлний нэрийн хамаатуулах ёсыг биед хамаатуулах болон эзэнд хамаатуулах гэж ангилдаг. Нэрийн хамаатуулах ёс нь

* МУИС, Шинжлэх ухааны сургууль, Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим, докторант

бүтээврээр илрэх бөгөөд нэр үгэнд залгагдаж тухайн нэр үг хэнд хамаатай болохыг харуулдаг.

Биед хамаатуулах ёс нь 3 биед тус тус ялган хамаатуулдаг бөгөөд 1-р биеийн хамаатуулах нь “минь”, 2-р биед хамаатуулах нь “чинь, тань”, 3-р биед хамаатуулах нь “нь” бүтээврээр тус тус илэрч, эзэнд хамаатуулах ёс нь “-аа” бүтээврээр илэрдэг.

Биеийн хамаатуулах ёсны бүтээврийн гарлын талаар 1, 2, 3-р биеийн төлөөний үгийн харьяалахын тийн ялгалын хувилбар болох миний, чиний, таны, үүний гэсэн үгнээс гаралтай гэж үздэг.

Биеийн хамаатуулах ёс нь яригч болон сонсогч, гуравдагч этгээдийн алинд нь харьяалагдахыг заадаг бол эзэнд хамаатуулах ёс нь 3 биеийн алинд нь хамаатуулж болдог.

5. Ах минь ирсэн
6. Ах чинь ирсэн.
7. Ах тань ирсэн.
8. Ах нь ирсэн.
9. Би номоо уншлаа.

Жишээ 5-8 дахь ах нь миний ах, чиний ах, таны ах, түүний ахыг зааж байгаа бол 9-р жишээний номоо гэсэн үг нь миний уншиж буй ном бол минийх болохыг заана.

Хамаатуулах ёсны талаарх өмнөх судалгаанууд нь хоёр үндсэн үүрэгтэй буюу 1-рт хэнд юунд хамаатай болохыг заах, 2-рт тухайн нэрийн зүйлийг төрлийнх нь олон юмын нэрсээс онцлон ялган заах юм гэжээ. Ш.Лувсанвандан үүнийг ялгах, үл ялгах ёсон хэмээн тодорхойлсон байдаг.

2.1. Эзэнд (ерөнхийлөн) хамаатуулах ёс

Тухайн хүн, юм үзэгдлийг үйлийн эзэнд нь бие ялгахгүйгээр хамаатуулах ёсыг эзэнд хамаатуулах ёс гэнэ. Эзэнд хамаатуулах ёс нь –аа, (-оо, -ээ, -өө) бүтээврээр илэрнэ.

Ш.Лувсанвандан (1968) эзэнд хамаатуулах ёсны талаар¹ дурьдахдаа монгол хэлний өгүүлбэрийн дотор орсон нэрийн зүйлийг ялган үзүүлэхдээ эзэмших юм, эзэмшигч эзэн хоёрыг нэгэн зэргээр илрүүлж, тухайн юм нь чухам хэний, юуны хамаатай болохыг зааж хамаатуулах ёсоор ялган үзүүлнэ. Эзэнд хамаатуулах ёс нь 3 биеийн алинд ч хэрэглэгдэж болох боловч тухайн өгүүлбэр ба хойдох урьдах өгүүлбэрийн утгаар гурван биеийн чухам аль нэгэнд хамаатуулж байгааг заавал ялган үзүүлнэ гэжээ.

10.а. Би номоо уншлаа.

б. Би өнөөдөр номын сангаас зээлсэн номоо уншлаа.

10.а. дээрх ном нь заавал миний ном байх ёстой. Гэтэл ном заавал минийх байх албагүй. Энэ нь өнөөдөр номын сангаас зээлсэн ном байж болно. Хэрэв хамаатуулах ёсоор тайлбарлаж гэвэл номын сангаас тодорхой хугацаагаар зээлсэн тул одоо надад хамаатай болсон гэж тайлбарлах хэрэгтэй болно. Мөн надад байгаа янз бүрийн ном дотроос номын сангаас зээлсэн номоо уншина гэсэн ялгах утгыг илэрхийлж байна хэмээн ялгах, үл ялгах ёсны үүднээс тайлбарлах ёстой.

11. а. Би ном уншлаа.

б. Би номоо уншлаа.

¹ Лувсанвандан нь эзэнд хамаатуулах ёсыг ерөнхийлөн хамаатуулах ёс гэж авч үзсэн байдаг.

12. а. Би морь эмээллэв.

б. Би морио эмээллэв.

Дээрх өгүүлбэрүүдийн ялгаа юу вэ? 11.а, 12.а жишээн дээр утгын өргөлт нь унших, эмээллэх гэсэн үйл үгүүдэд оногдож, би юу хийсэн бэ гэсэн санааг тодотгож өгнө. Харин “б” жишээний утгын өргөлт нь морио номоо гэсэн нэр үгэн дээр ногдоно.

Эзэнд хамаатуулах ёс буюу ерөнхийлөн хамаатуулах ёсны талаарх бас нэгэн тодорхойлолт нь тухайн юм үзэгдлийг бие ялгахгүйгээр үйлийн эзэнд нь хамаатуулах айг эзэнд хамаатуулах ай гэнэ гэжээ.²

Эзэнд хамаатуулах ёсны үйлийн эзэнд хамаатуулна гэсэн тодорхойлолтын дагуу унших, эмээллэх үйлийн эзэн нь би тул тухайн нэр нь надад хамаатай гэсэн утгыг заана гэсэн үг. Харин эзэмших юм, эзэмшигч эзэн хоёрыг зэрэг илрүүлэхдээ гурван биед ялгана гэсэн Лу багшийн тодорхойлсноор энэ өгүүлбэр нь би өөрийнхөө номыг уншиж, өөрийнхөө морийг эмээллэсэн гэсэн утгыг заахдаа 1-р биед хамаатуулна.

Эзэнд хамаатуулах ёс нь биед ялгана, ялгахгүй гэсэн ондоо тодорхойлолтууд гарч ирж байна.

13.а. Эх орноо хайрлацгаая.

б. Эх орныг хайрлацгаая. (?)

14. а. Чи цүнхээ энд тавиарай.

б. Чи цүнхийг энд тавиарай.

в. Чиний цүнхийг энд тавиарай. (?)

15. а. Бат цүнхээ энд тавиг.

б. Бат цүнхийг энд тавиг.

в. Батын цүнхийг энд тавиг.

16. а. Тэр цүнхээ тавиг.

б. Тэр цүнхийг энд тавиг.

в. Түүний цүнхийг энд тавиг.

Дээрх жишээнүүдэд хамаатуулах бүтээврээр хэлбэржсэн нь тухайн цүнх үйлийн эзэнийх болохыг зааж байна. Харин 13.б., 14.в. жишээ нь үйл үгийн шаардаж буй аргумент нь бүрэн бус байгаа тул зөв бус болж байна. Гэтэл нэг анхаарал татсан зүйл нь эзэнд хамаатуулах нөхцөл авсан тохиолдолд үйлийн эзэн байхгүй байгаа ч зөв өгүүлбэр болж өгч байгаа нь эдгээр нөхцөл нь энэ аргументийн үүргийг өмнөө байгаа нэрэнд нэгэнт оноож өгч чадаж байгааг харуулж байна. 14.а, 15.б, 16.б жишээн дээрх цүнх тухайн үйлийн эзэнтэй хамаатай байх албагүй юм.

Эзэнд хамаатуулах ай нь нэрлэхээс бусад тийн ялгалын дараа залгагдана. Мөн тэгээр илэрсэн заахын тийн ялгалын дараа залгагддаг.

17.а. Аваас асуу.

б. Аваасаа асуу.

18.а. (Тэр) Ахыг санаж байна. (?)

б. Ахаа санаж байна.

Монгол хэлний эзэнд хамаатуулах ёс нь ерөнхийлөн хамаатуулах утга бус харин тухайн юмсыг тухайн үйлийн эзэнтэй холбож өгч байгаа нь тодорхой байна. Тиймээс энэхүү

²⁾ Орчин цагийн монгол хэл, 2012, Улаанбаатар, Монгол Улсын Боловсролын Их Сургууль.

бүтээврээр үйлийн эзэнийг илрүүлж байгааг харж болох байна.
Нэгэнт үйлийн эзэнтэй холбогдож байгаа тул өгүүлбэрийн бүтцэд маш чухал үүрэгтэй байгаа нь харагдаж байна.

2.2. Биед хамаатуулах ёс.

Гурван биед хамаатуулах ёсыг харьяалахын тийн ялгалын төлөвт биеийн төлөөний нэрийг тухайн нэрийн дараа хэрэглэж үгүүлбэрийн зүйн аргаар илрүүлнэ гэж тодорхойлсон байдаг.

19. Ах **минь** ирлээ.

20. Ах **чинь** ирлээ.

21. Ах **нь** ирлээ.

Дээрх тод хараар бичсэн “минь чинь нь” нь гурван биед хамаатуулах ёсыг илрүүлэх үүргээр хэрэглэгдсэн харьяалахын тийн ялгалын төлөвт биеийн төлөөний бүтээвэр юм.

22. Миний ах ирлээ.

23. Чиний ах ирлээ.

24. Түүний ах ирлээ.

Харьяалахын тийн ялгалаар хэлбэржсэн төлөөний нэр болох “миний, чиний, түүний” болон хамаатуулах бүтээвэр болох “минь, чинь, нь” хоорондоо утга үүргийн хувьд ямар ялгаатай талууд байгааг илрүүлэх шаардлагатай.

Ш. Лувсанвандан хамаатуулах ёсны өгүүлбэрийн дотор гүйцэтгэх үүрэг нь юуны өмнө тухайн нэрийн зүйлийг төрлийнх нь олон юмны нэрээс онцлон ялган заах явдал юм гэсэн байдаг.

Биед хамаатуулах нөхцөл нь эзэнд хамаатуулах нөхцөлийн нэгэн адил маш өргөн утгаар хэрэглэгддэг. Ялангуяа гуравдугаар биеийн хамаатуулах -нь бүтээврийн талаар маш сонирхолтой зүйлс ажиглагддаг.

25. Түүний ах нь иржээ.

Харьяалахын тийн ялгалаар хэлбэржсэн гуравдугаар биеийн төлөөний нэр, гуравдугаар биеийн хамаатуулах бүтээврийн аль аль нь орсон жишээ байна. Энэ тохиолдолд -нь хамаатуулах утга илэрхийлж байна гэж үзэхэд хэцүү болно. Ялгах, үл ялгах ёсны дагуу тайлбарлах тохиолдолд ахыг ямар зүйлээс ялгаж байгааг мөн тодорхойлоход төвөгтэй. Эгч юмуу дүү нь биш ах нь иржээ хэмээн ялгасан гэж тайлбарлах хэрэгтэй болно.

26. Дүү минь ирээ юү?

27. Дүү чинь ирээ юү?

28. Дүү нь ирээ юү?

Дээрх өгүүлбэрүүд гурван биед ялган хамаатуулсан мэт байгаа боловч нөхцөл байдлаас хамаарч өөрөөр тайлбарлагдаж болно.

29. Миний хүү, ээж нь сайн уу?

30. Миний хүү, ээж чинь сайн уу?

2,3-р биеийн хамаатуулах бүтээврээр хэлбэржсэн ээж нь ижил хүн байна. Угтаа чиний ээж, түүний ээж гэсэн санааг илтгэх ёстой. Үүнийг хэрхэн тайлбарлах вэ? Ялгах, үл ялгахын ёсоор тайлбарлахад ч дутмаг байна. Дээрх жишээнээс харахад биеийн хамаатуулах нөхцөл 3 биед чөлөөтэй хэлбэржиж чадаж байна.

Биед хамаатуулах нөхцөл нь бүх нэрийн тийн ялгалын дараа залгагдаж болдог.

А. Нэрийн тийн ялгалын дараа залгагдсан жишээ

Нэрлэх

- 31.а. Улаанбаатар хот минь Монгол Улсын нийслэл бөгөөд хамгийн том хот.
- б. Улаанбаатар хот чинь Монгол Улсын нийслэл бөгөөд хамгийн том хот.
- в. Улаанбаатар хот нь Монгол Улсын нийслэл бөгөөд хамгийн том хот.

Харьяалах

- 32.а. Ахын минь морь түрүүлжээ.
- б. Ахын чинь морь түрүүлжээ.
- в. Ахынх нь морь түрүүлжээ.

Өгөх орших

- 33.а. Дүүд минь хоол хийж өгөөч.
- б. Дүүд чинь хоол хийж өгчихөөд ирье.
- в. Дүүд нь хоол хийж өгчихөөд ирье.

Заах

- 33.а. Аавыг минь байхад мөн ч сайхан байж дээ.
- б. Аавыг чинь байхад мөн ч сайхан байж дээ.
- в. Аавыг нь байхад мөн ч сайхан байж дээ.

Гарах

- 34.а. Ааваас минь үлдсэн хамгийн үнэтэй зүйл энэ дээ.
- б. Ааваас чинь үлдсэн хамгийн үнэтэй зүйл энэ дээ.
- в. Ааваас нь үлдсэн хамгийн үнэтэй зүйл энэ дээ.

Үйлдэх

- 35.а. Ахаар минь явуулсан захиаг чи авсан уу?
- б. Ахаар чинь явуулсан захиаг чи авсан уу?
- в. Ахаар нь явуулсан захиаг чи авсан уу?

Хамтрах

- 36.а. Дүүтэй минь найзалдаг хүүг чи мэдэх үү?
- б. Дүүтэй чинь найзалдаг хүүг чи мэдэх үү?
- в. Дүүтэй нь найзалдаг хүүг чи мэдэх үү?

Чиглэх

- 37.а. Гэр лүү минь чиглээд хэсэг морьтон айсуй.
- б. Цэцэг рүү чинь ус цацчих уу?
- в. Гар луу нь цохиод авав.

Дээрх жишээнүүдийг харахад биеийн хамаатуулах ёс нь 1-рт, биед ялгахдаа зөвхөн 1, 2-р биед тодорхой харагдаж байгаа ч 3-р биеийн нь бүтээвэр нь 3 биед аль алинд хамааруулж чадаж байгаа харагдана. 2-рт төрлийнх нь зүйлээс онцлон ялгасан гэсэн утгыг заадаг гэж үзэх боломжгүй байгааг маш тодорхой харуулж байна.

Б. Тийн ялгалаас бусад тохиолдолд залгагдсан жишээ

- 38.а. Хог новш энд тэнд минь хөглөрнө.
 - б. Хог новш энд тэнд чинь хөглөрнө.
 - в. Хог новш энд тэнд нь хөглөрнө.
- 39.а. *Өглөө минь эрт босов.
 - б. * Өглөө чинь эрт босов.

- в. Өглөө нь эрт босов.
- 40.а. *Хоол хурдан идэх минь эрүүл мэндэд хортой.
 - б. Хоол хурдан чинь эрүүл мэндэд хортой.
 - в. Хоол хурдан идэх нь эрүүл мэндэд хортой.
- 41.а. Ирэхлээр минь яваарай.
 - б. Ирэхлээр чинь явна.
 - в. Ирэхлээр нь явна.
- 42.а. Ирэнгүүт минь намайг барьчихсан.
 - б. Ирэнгүүт чинь явъя.
 - в. Ирэнгүүт нь явцгаая.
- 43.а. Очмогц минь тосоод аваарай.
 - Ирмэгц чинь уулзъя.
 - Явмагц нь хөдөлцгөөе.
- 44.а. Унттал минь хүлээж байгаарай.
 - б. Явтал чинь хүлээж байя.
 - в. Иртэл нь байж бай.

Дээрх жишээнүүдээс ажиглахад цагийн нэрсийн дараа залгагдахдаа зөвхөн 3-р биед залгагдаж 1, 2-р биед хязгаарлагдмал байгаа нь утгын хязгаарлалтаас хамаарч байна. Цагт нэр болон үйлийн тийн ялгалын дараа залгагдах боломжтой харагдаж байна.

3. Хамаатуулах ай ба онцолбор гишүүн

3.1 Онцолбор гишүүний онцлог

Миний аав, аав минь гэсэн илэрхийллийн хооронд ямар ялгаа харагдана вэ? Миний аав нь шууд харьяалах утгаа илэрхийлж байгаа бол аав минь гэсэн нь онцолсон утгыг харуулж байна. “Аав” өгүүлбэрт өгүүлэгдэхүүн болох бол харин “аав минь” онцолбор гишүүн болно хэмээн таамаглаж болох юм.

Онцолбор ба дэвсвэр гишүүн буюу суурь мэдээлэл ба тулгар мэдээлэл (Topic-Comment³) гэсэн ухагдахуун нь хэв шинжийн талаас хэлийг судлахад гол үндсэн ойлголт болдог юм.

Онцолбор ба дэвсвэр гишүүний тухай ойлголт маш чухал болохыг нотолсон янз бүрийн судалгаанууд хийгдсээр ирсэн. Li & Thompson (1976) –д онцолбор гишүүний үүргээр хэлийг ангилж авч үзсэн байдаг.

1. Өгүүлэгдэхүүнийг чухалчилсан хэл: Энэтхэг-Европийн хэл, Нигер Конгогийн хэл гэх мэт хэлнүүд багтана.
2. Онцолбор гишүүнийг чухалчилсан хэл: Хятад, Лаху, Лизу гэх мэт хэлнүүд багтана.
3. Өгүүлэгдэхүүн болон онцолбор гишүүнийг чухалчилсан хэл: Япон, солонгос гэх мэт хэлнүүд багтана.
4. Өгүүлэгдэхүүн онцолбор гишүүнийг чухалчилдаггүй хэл: Тагалог, Иликано гэх зэрэг хэлнүүд багтана.

Дээрхи ангиллаас харвал монгол хэлтэй төрөл хэлэнд багтах япон солонгос хэлнүүд

³⁾ (Topic-comment) гэсэн ухагдахууны талаар янз бүрээр тодорхойлсон байдаг. Онцолбор ба дэвсвэр, сэдэв-тайлбар, шинэ мэдээлэл-хуучин мэдээлэл, суурь мэдээлэл-тулгар мэдээлэл, тема-рема гэх мэт.

нь өгүүлэгдэхүүн, онцолбор гишүүний аль алийг чухалчилдаг хэл ажээ. Хэрэв тийм бол монгол хэлэнд ч мөн өгүүлэгдэхүүнээс гадна өгүүлбэрийн онцолбор гишүүн байж болно гэсэн таамаглал дэвшүүлж болохоор харагдаж байна.

Харилцах түвшинд эс ялгасан, чухалчлагдаагүй тэр хэсгийн дэвсвэр дээр ялган онцолж, шинэ мэдээлэл эсвэл нэмэлт мэдээлэл болгож өгүүлэмжийн төвийг бүтээж, утга санааны цөм болж байгаа хэсгийг өгүүлбэрийн онцолбор гишүүн гэнэ.

Ли Томсон наронцолбор гишүүний шинжүүдийг өгүүлэгдэхүүнээс ялгарах дараахонцлог шинжүүдтэй байдаг хэмээн тодорхойлсон байдаг.

(а) Тухайлах шинж (definite)

Онцолсон гишүүний нэг шинж чанар нь тухайлсан шинж чанар юм. Өөрөөр хэлбэл онцолбор гишүүн тухайлсан утгыг илэргхийлсэн байх ёстой.

(б) Өгүүлэхүүнээс үл хамаарах

Онцолбор гишүүн нь өгүүлбэр дэх үйл үгтэй заавал хамааралтай байх шаардлагагүй буюу өгүүлэхүүний бүрэлдэхүүний гол гишүүн байх албагүй гэсэн үг. Үйл үг нь өгүүлэгдэхүүнийг илрүүлдэг ба харин онцолбор гишүүнийг илрүүлдэггүй. Хэрвээ үйл үг нь эс тусах үйл үг байвал эдлэн үйлдэгч болон эрхэн үйлдэгчийн аль нэг нь тухайн үйл үг үйл хөдлөл заасан үйл үг, байдал заасан үйл үгийн аль нь вэ гэдгээс хамааран өгүүлэгдэхүүн болдог. Үйл үг нь шалтгаан заасан үйл үг бол шалтгаалан үйлдэгч өгүүлэгдэхүүн болдог.

Харин онцолбор гишүүн үйл үгээр шийдэгддэггүй буюу онцолбор гишүүний сонголт нь үйл үгнээс бие даасан байдалтай байдаг. Цогцолбор яриа (discourse) нь онцолбор гишүүний сонголтод гол үүрэг гүйцэтгэдэг бол харин цогцолбор ярианы хязгаарлалтан дор яригчид үйл үг нь ямар байхаас үл хамаарсан онцолбор гишүүний сонголтын маш их өргөн эрх чөлөө байдаг

(в) Чадварын үүрэг (functional role)

Онцолбор гишүүн нь тодорхой хязгаарлагдмал хүрээнд гол өгүүлэхүүний үүрэг гүйцэтгэх боломжийг хязгаарлана. Онцолбор гишүүн цаг, байдал, эсвэл гол өгүүлэхүүнд байгаа бие даасан ойлголтын хүрээг тогтоож өгдөг. Энэхүү үүрэг нь тодорхой бус онцолбор гишүүн байж болно гэсэн боломжийг хязгаарлаж байна. Харин өгүүлэгдэхүүн нь үйл үгээр илэрхийлэгдсэн үйл явдал, байдал туршлага зэргийн чиг хандлага, үзэл бодлыг тогтоодог.

(г) Үйл үгийн зохицол

Өгүүлбэрийн үйл үг нь өгүүлэгдэхүүнтэйгээ зохицодог хэлнүүд байдаг. Гэтэл онцолбор гишүүн өгүүлэхүүнтэйгээ зохицох тохиолдол маш ховор бөгөөд ийм үзэгдэл элбэг байх эсвэл зайлшгүй тохиолддог хэл байхгүй.

(д) Өгүүлбэрийн эхэнд байрлах

Онцолбор гишүүн нь өгүүлбэрийн эхэнд байрлах ёстой бол өгүүлэгдэхүүн нь эхэнд тохиолдохгүй байж болно.

3.2. Монгол хэлний хамаатуулах ёсны онцлог

Монгол хэлний хамаатуулах ёсонд хамаатуулах, ялгах гэсэн үүргээс гадна нэлээд сонирхолтой үзэгдлүүд ажиглагддаг.

(А) Гурван биед давхар хэрэглэх

Жишээ нь:

- 42. Ээж нь хоол хийгээд өгье.
- 43. Миний хүү, ээж нь ирсэн үү?
- 44. Ээж нь түүнийг аваад явсан гэнэ

Жишээ 42. нь ээж өөрийгөө зааснаар нэгдүгээр биеийг, 43 дээр 2-р биеийг, 44 дээр 3-р биеийг зааж байна. 3-р биед хамаатуулах ёстой атал гурван биед хамаатуулж чадаж байгааг хэрхэн тайлбарлах вэ?

Дээрх бүх жишээнүүдээс нийтлэг илэрч буй шинж нь хамаатуулах нөхцөл нь тухайн нэрийн зүйлээ онцолж өгч байгаа харагддаг. Тиймээс хамаатуулах нөхцөлийг онцолбор гишүүн байж болох юм гэсэн таамаглалыг дэвшүүлж болох юм.

45. Ээж гэртээ байна. (өгүүлэгдэхүүний утгаар орсон ээж гэсэн үгэнд тухайлсан шинж байхгүй.)

46. Ээж нь гэртээ байна. (Ээж өөрийгөө заан нэрлэсэн тухайлах шинж, эсвэл түүний ээж гэсэн тухайлсан шинжтэй байна.)

47. Ээж минь гэртээ байна. (Миний ээж гэртээ байна гэсэн тухайлсан утгыг заасан)

48. Ээж чинь гэртээ байна. (Чиний ээж гэртээ байна гэсэн тухайлсан утгыг заасан)

Дээрх жишээнүүд нь онцолбор гишүүний тухайлсан шинжтэй нийцэж байна.

49. Би явья.

50. Ах нь явья (Гуравдугаар биеийн –нь нөхцөлөөр нэгдүгээр биеийн заасан.)

51. *Ах явья.

Явья гэсэн үйл үг нь биеэр төгсгөх нөхцөлөөр хэлбэржсэн бөгөөд нэгдүгээр бие учир нэгдүгээр биеийн төлөөний үг болох би-тэй зохицож байна. Ах гэсэн үг нь нэгдүгээр биеийг заахгүй тул зохицож чадахгүй байна. Харин -нь нөхцөлөөр хэлбэржсэний дараа тухайн өгүүлбэр нь зөв өгүүлбэр болж чадаж байна. –нь нөхцөл нь гуравдугаар биед хамаатуулах утгыг заах атал нэгдүгээр биеийн төгсгөх нөхцөлөөр хэлбэржсэн үйл үгийн өмнө орсон. Энэ нь үйл үгтэй зохицох албагүй гэсэн онцолбор гишүүний онцлогтой нийцэж байна гэж үзэж болохоор байна.

52. *Түүний ах нь явья.

Ийм тохиолдолд түүний гэсэн гуравдугаар бие нь зайлшгүй гуравдугаар биеэр төгсгөх нөхцөл шаардах учир зөв бус өгүүлбэр болж байна.

(Б) Хураасан нэрийг шууд орлох чадвар

53. Сайн нь иржээ.

Дээрх өгүүлбэрт сайн гэсэн тэмдэг нэрийг -нь хамаатуулах нөхцөлөөр үйлийн эзэн болгожээ. Хэрвээ –нь нөхцөлийг авчихвал сайн иржээ гээд шал өөр утгатай өгүүлбэр болон хувирна.

54. Сайн иржээ.

Хэрэв -нь нөхцөлийг хасвал сайн гэдэг тэмдэг нэр нь үйлийн тодотгогчийнхоо үүргээр л орж үйл үгтэйгээ зохицож байна.

Хэдийгээр өнгөн бүтцэд сайн гэсэн тэмдэг нэр -нь нөхцөлөөр хэлбэржин өгүүлэгдэхүүний үүргээр орсон мэт байгаа боловч утгын хувьд тэмдэг нэрийн шинж нь хадгалагдах тул -нь нөхцөл өгүүлэхүүнийг бүрэн илэрхийлж чаджээ.

(В) Бүхэл хэсгийн харьцааг заах

55.а. * Хөл доголсон морь

б. Хөл нь доголсон морь

Дээрх өгүүлбэрийн цөм өгүүлбэр нь морины хөл доголжээ байж таарна. Харин

морины тухай ярихдаа хөлийг нь онцгойлсон эсвэл, доголсон хөл бол мориных байсан гэсэн тухайлах утга буюу бүхэл хэсгийн харьцааг заахад хөл гэсэн нэрийн ард –нь нөхцөлийг залгажээ.

Харин -нь нөхцөлийг хасвал тухайн өгүүлбэр нь зөв бус өгүүлбэр болно.

Дээрх онцлогуудаас харахад монгол хэлний хамаатуулах нөхцөл нь онцолбор гишүүнийг илрүүлэгч нөхцөл байж болох боломжтой юм. Гэхдээ монгол хэлний онцолбор гишүүнийг илрүүлэгч нөхцөл нь гурван биеийг заах чадвартай байдгийг харуулж байна. Харин 1-р, 2-р бие нь зөвхөн тухайн биедээ ялгаж байсан бол 3-р биеийг заасан –нь нөхцөл нь харьцангуй чөлөөтэйгээр 3 биед хэлбэржиж чадаж байгааг харуулж байна. Энэ нь монгол хэлний бусад хэлнээс ялгагдах шинж бөгөөд монгол хэл нь үйлийн төгсгөх нөхцөл ч мөн биеэр ялгадаг тул бие заах хэлзүйн ай монгол хэлний бусад ижил төрлийн хэлнүүдээс ялгарах шинж болж байна.

4. Дүгнэлт

Дээрх ажиглалтуудаас харахад монгол хэлний биеийн хамаатуулах айг онцолбор гишүүнийг илрүүлэгч хэмээн авч үзэх бүрэн боломжтой харагдаж байна. Ийнхүү онцолбор гишүүнийг илрүүлэхдээ биеэр ялгадаг хэмээн үзэж болно. Үүнийг монгол хэлний үйлийн биеэр зохицох ёс байдагтай холбон тайлбарлаж болно. Өгүүлэгч болон сонсогчийн байр сууринаас хэнийг юуг хэрхэн яаж онцлохоос хамаарч биеийн нөхцөлийн хэлбэржих байдал чөлөөтэй байгаа харагдаж байна. Хамаатуулах ай хэмээн авч үзсэн тохилдолд үүсээд байсан гурван биед давхардуулан хамааруулж байсан асуудлыг тайлбарлах боломжтой болно гэсэн үг. Мөн монгол хэлний биеийн хамаатуулах нөхцөл нь бүх тийн ялгал болон тооны нэр, үйл нэрийн дараа залгагддаг байдлыг тайлбарлахад онцолбор гишүүний үүргээр тайлбарлах нь илүү оновчтой.

Мэдээж цаашид бүхий л хувилбаруудыг илүү нарийвчлан авч үзэх шаардлагатай бөгөөд монгол хэлний онцолбор гишүүний судалгаа нь онцолбор гишүүний талаарх судалгаанд шинэ санааг дэвшүүлэх бүрэн боломжтой харагдаж байна. Онцолбор гишүүний талаарх судалгаа нь хийгдсээр байгаа бөгөөд эрдэмтдийн санал бодол хоорондоо зөрөлдөөнтэй байдаг. Тиймээс ч энэхүү судалгаа нь ерөнхий ойлголт дээр түшиглэсэн асуудал дэвшүүлэх төдий судалгаа байхаас өөр аргагүй байлаа. Цаашид улам лавшруулан судлах шаардлагатай юм.

НОМЗҮЙ

Ш. Лувсанвандан, *Монгол хэлний өгүүлбэрзүйн асуудлууд*, Улаанбаатар, 2000

Ш.Лувсанвандан, *Ялгах, Үл ялгахын ёсон*, Улаанбаатар, 1953

Орчин цагийн Монгол хэл, МУБИС, Улаанбаатар, 2012

БНМАУ-ын ШУА, *Орчин цагийн монгол хэлзүй*, Улаанбаатар 1966

Чарльз Ли, Сандра Томсон, *Өгүүлэгдэхүүн ба онцолбор гишүүн*, 1976

ABSTRACT

In this article I have attempted to suggest Mongolian nominal possessive category.. Mongolian nominal possessive category was determined into two study areas such as relative value and distinctive value. However, when we apply to the usage of the Mongolian nominal possessive predicament there are some very interesting and unique phenomena are observed. Therefore, this article aimed to reveal specificity effects while considering from different aspects of its usage and limitations or lack of bias of the previous studies. Especially, if we consider that Mongolian nominal possessive category modify only personal nouns could be a lack of bias. For example, In Mongolian nominal possessive category ‘нь’ was considered as determiner only relative clause to the third body.

Ээж нь хийе. (Let mother do it.)

Ээж нь хийв үү? (Did your mother have done it?)

Ээж нь хийжээ. (Her mother has done it)

In the above, ‘mother’ is in the three different possessive forms which can determine relative clause to the first body, also to the second body and to the third body. Likewise, I consider them as a unique feature of the Mongolian possessive category. Furthermore, in this article we aimed to propose a new theoretical idea concerning to Mongolian nominal possessive clause. Based on the study about topic clause, we are here intended to define the features of nominal possessive predicament. I have made major research focus on the Lee and Thompson’s overall view about topic and comment clause in this study. Mongolian nominal personal possessive category can be emphasize as a determiner of the topic clause. Thus, I came out to the conclusion that there is a possibility that can make rational reference in consideration of nominal possessive category.